



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1/280

Улаанбаатар хот

Аюултай ачаатай тээвэрлэгчид
үл харьяалагдах болон түрээсэлж авсан
вагоны зам ашиглалтын хөлс тооцох тухай

Зам, тээвэр хөгжлийн сайд, Тагнуулын Ерөнхий газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/71 дүгээр хамтарсан тушаал, Хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын дүрмийн 22 дугаар зүйлийн "а" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аюултай ачаатай тээвэрлэгчид үл харьяалагдах болон түрээсэлж авсан вагонуудын өртөө, зөрлөгүүд дээрх сул зогсолт эрс нэмэгдэж аюултай нөхцөл байдал үүсэн тээврийн технологийн үйл ажиллагаа алдагдаж байгаа тул үүссэн нөхцөл байдлыг бууруулах зорилгоор аюултай ачаатай ирсэн тээвэрлэгчид үл харьяалагдах болон түрээсэлж авсан вагоны өртөөний замд хүлээлгэнд зогсох үеийн зам ашиглалтын хөлсийг хавсралт ёсоор баталж 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэхдээ холбогдох алба, ажилтнуудад тараах, зааварчилгаа өгөх, программ хангамжид зохих өөрчлөлтийг оруулах, тарифын өөрчлөлтийг www.ubtz.mn цахим хуудсанд байршуулах, үйлчлүүлэгч, олон нийтэд зарлан мэдээлэхийг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (Усольцева С.Я), Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга (З.Энхбаяр), Тээвэр зохион байгуулалтын албаны дарга (Б.Мөнхтулга), Статистик бүртгэлийн төвийн дарга (Д.Тамир), Мэдээллийн технологийн албаны дарга (Х.Анар) нарт тус тус даалгасугай.

3. Тушаал батлагдсантай холбогдуулан Замын даргын 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 285Б тоот цахилгааныг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга (Д.Амарбаясгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

1601251754

“УБТЗ” ХНН-ийн даргын оны дүгээр
сарын ны өдрийн дугаар
тушаалын хавсралт



**Аюултай ачаатай тээвэрлэгчид үл харьяалагдах болон
түрээсэлж авсан вагоны зам ашиглалтын хөлс**

1. Аюултай ачаатай ирсэн тээвэрлэгчид үл харьяалагдах болон түрээсэлж авсан вагоны өртөө, зөрлөгийн замд хүлээлгэнд зогсох үеийн зам ашиглалтын хөлсийг вагон бүрээс дараах байдлаар тооцно.Үүнд:

- хүлээлгийн санамж нээсэн цагаас эхлэн 0-6 цаг хүртэлх хугацаанд зогссон тохиолдолд 0 төгрөг,
- 6 цагаас дээш дараагийн 12 цагийн хугацаанд зогссон тохиолдолд 40000 төгрөг,
- хүлээлгийн санамж нээсэн цагаас хойш 18 цагаас дээш хугацаанд зогссон тохиолдолд 1 цаг тутамд 5000 төгрөг.

2. Төмөр замын мэдлийн зам дээр аюултай ачааны ачилтад тавьж өгсөн тээвэрлэгчид үл харьяалагдах болон түрээсэлж авсан вагоны зам ашиглалтын хөлсийг вагон бүрээс дараах байдлаар тооцно.Үүнд:

- санамж нээсэн цагаас эхлэн 0-6 цаг хүртэлх хугацаанд 0 төгрөг,
- 6 цагаас дээш дараагийн 12 цагийн хугацаанд 40000 төгрөг,
- санамж нээсэн цагаас хойш 18 цагаас дээш хугацаанд зогссон тохиолдолд 1 цаг тутамд 5000 төгрөг,

3. УБТЗ-аас шалтгаалсан сул зогсолтын хугацааг ерөнхий маягтын актаар тодорхойлон хасаж тооцно.